

**ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 06 дугаар сарын 12

Улаанбаатар хот

Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ын 2.4, 2.5-ын дагуу хяналт шинжилгээ хийж дүгнэв.

Газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 4 бүлэг, 39 зорилт, 135 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөн, тус газрын удирдлага Төсвийн Ерөнхийлөн захирагч буюу Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 01/47 дугаартай “Хариуцлагын гэрээ” байгуулагдаж, хагас жилийн байдлаар 89,1 хувийн хэрэгжилттэй үнэлэгдсэн.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан зорилт, арга хэмжээ:

№	Зорилго	Зорилтын тоо	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5
1	Төсөл арга хэмжээний хүрээнд	2	2	100,0%
2	Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд	26	55	78,7%
3	Хуулиар хүлээх чиг үүргийн хүрээнд	10	73	95,8%
4	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилтын хүрээнд	1	5	100,0%
Нийт		39	135	89,1%

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 135 ажил, арга хэмжээний хэрэгжилтийн хувь:



Үүнээс бүрэн хангалттай (85%-иас дээш) 113 арга хэмжээ, хангалттай (70-84% хүртэл) 11, хангалтгүй (69% хүртэл) 10, хугацаа болоогүй 1 арга хэмжээ үнэлэгдсэн.

Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн 10 арга хэмжээ:

Д/д	Хэрэгжилт хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээнүүд	Хэрэгжилтийн хувь	Шалтгаан, тайлбар
1	2	3	4
1	3.5.4. Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн салбар чиглэлээр төрөлжүүлж дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дээд газарт санал хүргүүлэх	30	Зарим их, дээд сургуулийг дагуул хотод нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд Хүннү хотын Оюутны хотхон эрдэм шинжилгээний бүсэд их дээд сургуулиудыг шат дараатай нүүлгэн шилжүүлэх судалгаа Koica судалгааны байгууллагаас боловсруулагдаж байна. Тус ажлыг Хүннү хотын Захирагчин ажлын албанаас хариуцан ажиллаж байгаа болно.
2	2.4.1. Авто замын бүтээн байгуулалтын хүрээнд 127,4 км замын ажлын даалгавар боловсруулах	-	Хүннү хотын ажлын алба хариуцаж байна.
3	2.5.1. "Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж" хотын стандартын төслийг боловсруулах	30	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт тус ажлын хөрөнгө оруулалтын саналыг тусгуулахаар 2026 оны 01/815 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй
4	2.5.3. Суурьшлын бүс дэх тэжээвэр амьтдын хотын стандартын төслийг боловсруулах	30	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газарт тус ажлын хөрөнгө оруулалтын саналыг тусгуулахаар 2026 оны 01/815 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй
5	2.7.2. Алслагдсан 3 дүүргийн төвийн хэсгийн 20000 га талбайд 1:1000-ны масштабтай байр зүйн зураглал хийх	0	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй /Төсвийн тодотголд санал хүргүүлэх/
6	2.7.3. Хот байгуулалтын мэдээллийн сангийн аюулгүй байдал хангах, сервер, компьютерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шинэчлэх	0	Хөрөнгө шийдвэрлэгдээгүй /Төсвийн тодотголд санал хүргүүлэх/
7	2.1.1. Улаанбаатар хотын Хот байгуулалтын бүсчлэлийн дүрэмд санал өгөх	0	Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоосны үндсэн дээр Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг баталж, Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажил хийгдэх тул Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа дээрх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэх боломжтой.
8	2.2.2.Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах	0	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолоор батлагдсаны дараа Монгол Улсын Засгийн газарт өргөн барихаар ажиллаж байна.
9	2.3.6. Шинээр байгуулах 14 хотын хөгжлийн бодлогын судалгаанд математик загварчлал боловсруулж, дүн шинжилгээ хийх ажилд санал өгөх	0	Шинээр байгуулах 14 хотын үндэслэл болох Улсын Их Хурлын 72 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх чиглэл ирээгүй тул одоогоор санал өгөөгүй.
10	2.23.2 Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" хотын стандартын хэрэгжилтийг хангуулах талаар	0	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/05 дугаар тогтоолоор батлагдсан "UCS0302B:2025 Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага"

арга хэмжээг дүүргүүдийн Засаг даргын тамгын газар, тухайн чиг үүргийг хэрэгжүүлэгч нутгийн захиргааны байгууллагууд болон Буяны зан үйлийн холбоо ТББ, Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй байгууллагуудтай хамтран зохион байгуулах	хотын стандартыг сурталчлан таниулах ажлыг сүүлийн хагас жил хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
--	---

**Нэгжүүдийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
эхний хагас жилийн хэрэгжилт:**

Д/д	Алба, хэлтэс	Эхний хагас жилийн хэрэгжилт	
		Зорилт, арга хэмжээ (давхардсан тоогоор)	Хэрэгжилтийн Хувь
1	2	3	4
1	Захиргаа, удирдлагын хэлтэс	2 зорилт, 31 арга хэмжээ	97,7%
2	Ерөнхий архитекторын ажлын алба	10 зорилт, 39 арга хэмжээ	96,5%
3	Барилга, хот байгуулалтын хэлтэс	3 зорилт, 46 арга хэмжээ	100%
4	Хот төлөвлөлтийн хэлтэс	8 зорилт, 30 арга хэмжээ	96,7%
5	Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс	23 зорилт, 52 арга хэмжээ	98,8%
6	Хотын орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс	8 зорилт, 35 арга хэмжээ	85,0%
7	Барилга байгууламжийн чанар, стандартын хэлтэс	6 зорилт, 26 арга хэмжээ	93,3%
8	Дэд төв, дагуул хотын хөгжлийн хэлтэс	9 зорилт, 35 арга хэмжээ	95,0%
9	Хотын стандарт, хөгжлийн хэлтэс	9 зорилт, 36 арга хэмжээ	99,2%
10	Хот байгуулалтын хяналтын хэлтэс	6 зорилт, 25 арга хэмжээ	100,0%
11	Хуулийн хэлтэс	8 зорилт, 28 арга хэмжээ	98,2%
ХОТ БАЙГУУЛАЛТ, ХОТЫН СТАНДАРТЫН ГАЗАР		39 зорилт, 135 арга хэмжээг	89,1%

Хяналт, шинжилгээний хийхэд нэгжийн үнэлгээг журмын дагуу өөрчилсөн заалтууд:

д/д	Заалт	Хэрэгжилт	Нэгж ийн үнэл гээ	Өөрчлөгд сөн үнэлгээ
1	2.8.1 Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг хийх.	Тус ажлын үлдэгдэл санхүүжилт нь 2026 оны төсөвт шилжиж, батлагдсан. Ажлын гэрээний хугацааг 2026.02.10- 2026.09.30-ны өдрийг хүртэл НХААГ/20240103238-3 дугаартайгаар сунгасан. Ажлын явцтай танилцан зураглалын явц, байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдгийн стандарт MNS 6702:2017, MNS 6925:2021	70	80

		стандартуудыг мөрдлөг болгон ажиллах, стандартад хөрвүүлэх талаар зөвлөмж өгсөн. Хотын төвийн Нарны зам дагуу байрлах 1.5 км зурвас орчмын байр зүйн зураглал, ортофото зургийг урьдчилсан байдлаар ирүүлснийг шалгахад байрзүйн зураглал стандартын дагуу бус, тодруулгын хэмжилт хийгдээгүй, байрзүйн зурагт шат, довжоо болон барилгын орц гарц дутуу зурагдсан, барилга байгууламжийн давхрын мэдээлэл дутуу мэдээллийн сан үүсгэсэн байсан тул ажлын зургийн даалгаварт заасан шаардлагын дагуу зөвлөгөө өгч, зургийг буцаан засварлуулж байна.		
2	2.14.1 Яармаг хотын шинэ төвд 93МВт-ийн дэвшилтэт технологи бүхий дулааны эх үүсвэрийн газар олголтыг шийдвэрлүүлж, ажлын даалгавар боловсруулах, ТЭЗҮ, ажлын зураг төсөл зөвшилцөх,	Тус төслийн нийт санхүүжилтийг Улс, нийслэл, гадаадын хөнгөлөлттэй зээл, тусламжаар шийдвэрлэхээр тусгасан. ХУД-ийн 8 дугаар хороонд төвлөрсөн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 93 МВт-ын эх үүсвэр барихад шаардлагатай 3.5 га газар шаардлагатай тул газар олголтын асуудлыг яаралтай шийдвэрлэж өгөх тухай 2026 оны 02/335 дугаартай албан бичиг хүргүүлсэн.	85	70
3	2.17.3 Шинээр баригдах үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын зураг зөвшилцөн, хот байгуулалтын мэдээллийн санд оруулах	Үерийн далан сувгийн 11 ажлын зургийн даалгавар боловсруулж, захиалагчид хүргүүлсэн. Үүнд: ➢ ЧД-ийн 2 байршил, ➢ СХД-ийн 4 байршил, ➢ ХУД-ийн 4 байршил, ➢ СБД-ийн 1 байршил.	70	100
4	3.5.4 Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн салбар чиглэлээр төрөлжүүлж дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дээд газарт санал хүргүүлэх	Зарим их, дээд сургуулийг дагуул хотод нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд Хүннү хотын Оюутны хотхон эрдэм шинжилгээний бүсэд их дээд сургуулиудыг шат дараатай нүүлгэн шилжүүлэх судалгаа Koica судалгааны байгууллагаас боловсруулагдаж байна. Тус ажлыг Хүннү хотын Захирагчин ажлын албанаас хариуцан ажиллаж байгаа болно.	50	30
5	3.8.1 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээ олгох	Засгийн газрын 2021 оны 213 дугаар тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-ийн хэрэгжилтийн хүрээнд Барилгын ажлын зөвшөөрөл авах 806 хүсэлтийг хүлээн авч Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг олгосон 472, судалж байгаа 128 хүсэлт, материалын бүрдэл дутуу, шаардлага хангахгүй 206 хүсэлтийг буцааж хариу өгч шийдвэрлэсэн. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалттай 34 барилга байгууламж: - Сургууль-11 - Цэцэрлэг-10 - Эмнэлэг-5 - Олон нийтийн барилга-8	50	100

Нийт 472 барилга
- Барилга-238
- Цахилгаан хангамж-200
- Барилга буулгах-16
Шугам сүлжээ-18

САНАЛ, ЗӨВЛӨМЖ:

2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг алба, хэлтсүүдэд өгч байна. Үүнд:

1. Хангалтгүй үнэлэгдсэн буюу хөрөнгө шийдвэрлэгдээгүйн улмаас хэрэгжих нөхцөл бүрдээгүй арга хэмжээг Улс, нийслэлийн 2026 оны төсвийн тодотголд тусгуулах ажлыг зохион байгуулах,

2. Хангалттай буюу 70-85 хүртэл хувь үнэлэгдсэн 11 ажлыг үлдсэн хугацаанд зорилтот түвшинд бүрэн хүргэж, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулан эрчимжүүлж ажиллахад нэгжүүд анхаарч ажиллах,

3. Газрын үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэж, мэдээллийн ил тод байдлыг ханган, цахим <https://uds.ub.gov.mn/> веб хуудсанд алба, хэлтсүүд өөрсдийн хариуцан гаргах мэдээ, мэдээллийг цаг тухай бүрд нь шинэчлэн байршуулах,

4. Газраас үзүүлж буй 9 төрлийн 37 үйлчилгээний шийдвэрлэлтэд (Баримт бичгийн бүрдэл, шийдвэрлэлтийн хугацаа, үйлчилгээний тайлан мэдээ, хандалт, цаашид шийдвэрлэх зарим асуудал гэх мэт.) тогтмол хяналт тавьж ажиллах

5. Албан бичиг, өргөдөл гомдлын зөрчилгүй ажиллах шаардлагатай.

ТАНИЛЦСАН: ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Б.ДУЛАМСҮРЭН